



2020 оны 07 дугаар сарын 20
№27 /1129/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
хууль**

**Монгол Улсын Засгийн газрын
тухай хуульд өөрчлөлт
оруулах тухай**

**Монгол Улсын
Их Хурлын
тогтоол**

**Монгол Улсын Их Хурлын
дэд дарга нарыг сонгох
тухай**

**Монгол Улсын
Ерөнхийлөгчийн
зарлиг**

**Элчин сайдыг эгүүлэн
татах, тохоон томилох
тухай**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

301.	Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрт оруулах нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай	1479
302.	Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1479
303.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1480
304.	Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1489
305.	Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1489
306.	Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1490
307.	Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1490
308.	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1492
309.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1493
310.	Улсын гэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1494
311.	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1496
312.	Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1497

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

313.	Монгол Улсын Их Хурлын дэд дарга нарыг сонгох тухай	Дугаар 04	1497
------	---	-----------	------



314.	Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай	Дугаар 05	1498
315.	Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүний тухай	Дугаар 06	1498
316.	Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн баглах тухай	Дугаар 07	1499
317.	Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай	Дугаар 08	1501
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ			
318.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 44	1502
319.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 45	1502
320.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 46	1503
321.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 47	1503
322.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 48	1504
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ			
323.	Журам батлах тухай	Дугаар 483	1504
324.	Журам батлах тухай	Дугаар 484	1511
МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ			
325.	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.2.9, 32.3.11 дэх заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай		1512
МОНГОЛ УЛС ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ			
326.	Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрт оруулах нэмэлт өөрчлөлт 2019-2020 оны зээлийн төлөвлөгөө		1531

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 04 дүгээр
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ХӨТӨЛБӨРТ ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдөр гарын үсэг зурсан “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрт оруулах нэмэлт, өөрчлөлт”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зэвсэгт хүчний тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.17 дахь заалт:

“3.1.17. “барилга-инженерийн цэрэг” гэж улсын онц чухал объект, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, салбарын барилга, инженерийн байгууламжийг барих, сэргээн засварлах, дайн байлдааны болон гамшгийн дараах сэргээн босгох, дотоод, гадаадад хүмүүнлэгийн тусламж, энхийг дэмжих ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцох цэргийн хүчнийг.”

2/6 дугаар зүйлийн 6.2.11, 6.2.12 дахь заалт:

“6.2.11. бүтээн байгуулалтын ажилд оролцох;
6.2.12. гадны кибер халдлага, түрэмгийллээс хамгаалах.”

3/11 дүгээр зүйлийн 11.1.15 дахь заалт:

“11.1.15. зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулах журмыг тогтоох.”



4/13 дугаар зүйлийн 13.1.13 дахь заалт:

“13.1.13.улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай мэргэжилтэй ажилтан бэлтгэх, цэргийн алба хаагчдыг мэргэшүүлэх, мэргэжил эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулах журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.”

2 дугаар зүйл.Зэвсэгт хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“7.3.Зэвсэгт хүчин нь Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлал, барилга-инженерийн цэргийн удирдах байгууллага, төрөл, тусгай мэргэжлийн болон кибер аюулгүй байдлын, ар тал, техникийн нэгтгэл, анги, салбар, цэргийн цагдаа, эмнэлэг, хангалт үйлчилгээний байгууллага, иргэн-цэргийн харилцааг зохицуулах нэгжтэй байна.”

3 дугаар зүйл.Зэвсэгт хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “хуурай замын цэрэг, агаарын цэргээс” гэснийг “хуурай замын цэрэг, агаарын цэрэг, барилга-инженерийн цэрэг, кибер аюулгүй байдлын цэрэг болон тусгай хүчний цэргээс” гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/18 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Засгийн газрын бүтцэд доор дурдсан яам ажиллана:

Ерөнхий чиг үүргийн:

- 1/Байгаль орчин, аялал жуулчлалын яам;
- 2/Батлан хамгаалах яам;



- 3/Гадаад харилцааны яам;
- 4/Сангийн яам;
- 5/Хууль зүй, дотоод хэргийн яам;
- 6/Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам;

Чиглэлийн:

- 7/Барилга, хот байгуулалтын яам;
- 8/Боловсрол, шинжлэх ухааны яам;
- 9/Зам, тээврийн хөгжлийн яам;
- 10/Соёлын яам;
- 11/Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам;
- 12/Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам;
- 13/Эрчим хүчний яам;
- 14/Эрүүл мэндийн яам.”

2/20 дугаар зүйлийн 4,5 дахь хэсэг:

“4.Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараах асуудал хамаарна:

бодлого;

- төрийн өмчийн бодлого;
- цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах

асуудал;

- тагнуул, сөрөг тагнуул, терроризмаас урьдчилан сэргийлэх

- төрийн тусгай хамгаалалтын асуудал;
- нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлого;
- мэргэжлийн спортын хөгжлийн асуудал.

5.Засгийн газрын гишүүн доор дурдсан хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхэлнэ:

1/Монгол Улсын Шадар сайд:

шуурхай асуудал;

- гамшгаас хамгаалах асуудал;
- хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаатай холбоотой

- стандартчилал, хэмжил зүйн асуудал;
- тохирлын үнэлгээний итгэмжлэлийн асуудал;



-шударга өрсөлдөөнийг дэмжих, хянан зохицуулах асуудал;
-хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах асуудал;
-тодорхой салбарын мэргэжлийн хяналтын асуудал;
-чөлөөт бүсийн хөгжлийн асуудал;
-төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа;

-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.

2/Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга:

-хөгжлийн бодлого, төлөвлөлт;
-эдийн засгийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, салбар, дэд бүтцийн зохистой харьцааг тогтоох асуудал;

-хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого;
-гадаадын хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалт, бүртгэл;

-концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлого;
-харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал;
-Засгийн газрын шийдвэрийн биелэлт;
-Засгийн газрын дотоод мэдээлэл;
-Засгийн газраас Улсын Их Хуралтай харилцах асуудал;
-төрийн албаны хүний нөөцийн асуудал;
-орон нутгийн хөгжлийн нэгдсэн бодлого;
-орон нутгийн засаг захиргааны зохион байгуулалт, удирдлага;
-Засаг даргын үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангах асуудал;

-иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд үзүүлэх мэргэжил, арга зүйн туслалцаа;

-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.

3/Байгаль орчин, аялал жуулчлалын сайд:

-ногоон хөгжлийн бодлого;
-байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх болон экологийн бодлого;
-газар зохион байгуулалт болон усны нэгдсэн бодлого;
-цөлжилттэй тэмцэх болон ойжуулалтын асуудал;
-усны нөөцийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах асуудал;

сан;
-ургамал, ан амьтны нөөцийг хамгаалах асуудал, мэдээллийн

-байгаль орчны шинжилгээ, ус, цаг уур болон байгалийн болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, экологийн аюулгүй байдлыг хангах асуудал;

-биоаюулгүй байдлын бодлогын асуудал;
-аялал жуулчлалын бодлого;
-салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ, ажлын байрыг нэмэгдүүлэх асуудал;

-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.

4/Батлан хамгаалахын сайд:

-улсыг батлан хамгаалах бодлого болон цэргийн бодлого;
-зэвсэгт хүчнийг чадваржуулах бодлого;
-энхийг дэмжих ажиллагаанд оролцох бэлтгэл хангуулах асуудал;

-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.

5/Гадаад харилцааны сайд:

-гадаад улс, олон улсын байгууллагатай улс төрийн талаарх хамтын ажиллагаа;

-гадаад эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа;
-гадаад худалдааны бодлого;
-гадаадад байгаа Монгол Улсын иргэн, бизнесийн эрх ашгийг хамгаалах асуудал;

-гадаад улс, олон улсын байгууллагатай хийх гэрээ, хэлэлцээрийн асуудал болон байгуулсан гэрээ, хэлэлцээрийн явцад тавих хяналт;

-гадаад улс, олон улсын байгууллагатай хүмүүнлэгийн чиглэлээрх хамтын ажиллагаа;

-дипломат, албан зэргийн виз, консулын асуудал;
-гадаад сурталчилгаа;
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.



6/Сангийн сайд:

-макро эдийн засгийн бодлогын төлөвлөлт, зохицуулалт;
-санхүүгийн зах зээл, төсвийн орлого, зарлага, өрийн удирдлагын асуудал;

-нэгдсэн төсвийн талаарх судалгаа, төлөвлөлт;
-улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийн асуудал;

-төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалт, санхүүжилтийн үйл ажиллагаа;

-улсын болон орон нутгийн төсвийн зарцуулалтын хяналт;
-зээл, тусламжийн нэгдсэн бодлого;
-нягтлан бодох бүртгэлийн бодлого;
-гаалийн бодлого;
-татварын бодлого;
-даатгалын бодлого;
-хилийн боомтын хөгжлийн асуудал;
-төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах бодлого;

-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.

7/Хууль зүй, дотоод хэргийн сайд:

-эрх зүйн шинэтгэлийн бодлого;
-хууль тогтоомжийн системчлэл, мэдээлэл, эрх зүйн сургалт, сурталчилгаа, судалгаа;

-эрх зүйн туслалцаа;
-улсын хил хамгааллын асуудал;
-цагдаа, нийгмийн дэг журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх асуудал;

-шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа;
-Засгийн газраас шүүх, прокурорын байгууллага, хуульчдын олон нийтийн байгууллагатай харилцах асуудал;

-төрөөс сүм хийдтэй харилцах асуудал;
-иргэний харьяалал, цагаачлалын асуудал;
-энгийн зэргийн виз, Монгол Улсад орох, гарах, оршин суух гадаадын иргэний асуудал;



-төрийн захиргааны байгууллагын шийдвэрийн хууль зүйн үндэслэлийн хяналт;

асуудал.
-иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл;
-хэвлэл, мэдээллийн хэрэгслийн бүртгэл;
-оюуны өмч, патент, зохиогчийн эрхийн асуудал;
-архивын талаар төрөөс баримтлах бодлого;
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх

8/Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд:

асуудал.
-хүн амын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал;
-нийгмийн халамжийн бодлого;
-нийгмийн даатгалын бодлого;
-хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд, ахмадын болон гэр бүлийн хөгжлийн асуудал;

асуудал.
-жендэрийн хөгжлийн асуудал;
-хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн асуудал;
-хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг багасгах, ядуурлыг бууруулах бодлого;

асуудал.
-хөдөлмөрийн нөхцөл, ажиллагчдын цалин, амьдралын ертгийн талаарх асуудал;

асуудал.
-хөдөлмөрийн харилцаа, Засгийн газар, эзэд, Үйлдвэрчний эвлэлийн гурван талт түншлэл, хөдөлмөрийн хамтын маргааны зохицуулалтын асуудал;

асуудал.
-хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалт;
-хөдөлмөрийн биржийн асуудал;
-Монгол Улсад хөдөлмөр эрхэлж байгаа гадаадын иргэний асуудал;

асуудал.
-гадаадад ажиллах хүч гаргах асуудал;
-мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн тогтолцоог хөгжүүлэх асуудал;

асуудал.
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.

9/Барилга, хот байгуулалтын сайд:

-барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлого;



-хот төлөвлөлт болон хот байгуулалтын бодлого, архитектурын асуудал;

-орон сууцны бодлого;
-нийтийн аж ахуйн асуудал;
-газрын харилцаа, геодези, зураг зүйн асуудал;
-салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ, ажлын байрыг нэмэгдүүлэх асуудал;

-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.

10/Боловсрол, шинжлэх ухааны сайд:

-боловсролын тогтолцоог хөгжүүлэх асуудал;
-шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын асуудал;
-өндөр технологи, үндэсний инновацийн тогтолцоог бүрдүүлэх, хөгжүүлэх асуудал;

-ном хэвлэл, цахим бичвэрийн бодлого;
-салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ, ажлын байрыг нэмэгдүүлэх асуудал;

-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.

11/Зам, тээврийн хөгжлийн сайд:

-авто замын асуудал;
-авто тээврийн асуудал;
-төмөр замын тээврийн асуудал;
-иргэний нисэхийн асуудал;
-далай ашиглах болон усан замын тээврийн асуудал;
-тээврийн тогтолцоог хөгжүүлэх бодлого, зохицуулалт;
-салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ, ажлын байрыг нэмэгдүүлэх асуудал;

-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.

12/Соёлын сайд:

-соёл, урлагийг хөгжүүлэх асуудал;
-түүх, соёлын өвийг хамгаалах, сэргээх бодлого;

-салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ, ажлын байрыг нэмэгдүүлэх асуудал;

-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.

13/Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд:

-геологи, эрдэс баялгийн бодлого;
-геологийн эрэл, хайгуул, судалгааны зохицуулалт;
-газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний нөөцийн талаарх бодлого;

-цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах асуудал;

-олборлох үйлдвэрийн техник, технологийн асуудал;
-ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх бодлого;
-хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудал;
-эрдэс баялаг болон хүнд үйлдвэрийн бүтээгдэхүүний экспорт, импортын асуудал;

-аж үйлдвэрийн паркийн асуудал;
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.

14/Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд:

-хүн амын хүнсний хангамжийн бодлого;
-хүнсний аюулгүй байдлын асуудал;
-мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого;
-газар тариаланг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого;
-мал эмнэлэг, малын үржлийн талаар төрөөс явуулах бодлого;

-мал, амьтан, ургамлын хорио, цээрийн асуудал;
-бэлчээрийн болон таримал ургамлыг хамгаалах асуудал;
-мал, таримал ургамлын гаралтай хүнсний зүйл, түүхий эд болон хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүний экспорт, импортын асуудал;

-хөдөө аж ахуйн эдэлбэр газрын болон бэлчээр ашиглалтын бодлого;

-малыг цаг агаарын гэнэтийн аюулаас хамгаалах бодлого;
-хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудал;
-жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийн асуудал;



асуудал.
-дотоод худалдаа, үйлчилгээний бодлого, зохицуулалт;
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх

15/Эрчим хүчний сайд:
-эрчим хүчний нэгдсэн бодлого;
-эрчим хүчний үйлдвэрлэлт, дамжуулалт, түгээлтийн асуудал;
-сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх асуудал;
-эрчим хүчний шинэ эх үүсвэрийг бий болгох, ашиглах
бодлого;

-түлшний хангамж, нөөцийн бодлого, зохицуулалт;
-эрчим хүч хэмнэлтийн бодлого;
-эрчим хүчний нүүрсний асуудал;
-салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ, ажлын байрыг
нэмэгдүүлэх асуудал;

асуудал.
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх

16/Эрүүл мэндийн сайд:
-хүн амын эрүүл мэндийг хамгаалах, нөхөн сэргээх бодлого;
-эм, эмнэлгийн хэрэгсэл, техникийн үйлдвэрлэл, хангамжийн
талаарх бодлого;

-эмнэлгийн үйлчилгээ, эрүүл ахуй, халдвар судлалын
хүрээний бодлого;

-хүн амын эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн болон
мэргэжлийн арга хэмжээ;

-салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ, ажлын байрыг
нэмэгдүүлэх асуудал;

-эрүүл мэндийн даатгалын бодлого, зохицуулалт;
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх
асуудал.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2020 оны 7 дугаар сарын 07-ны өдрөөс
эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БҮТЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 10 дахь заалт нэмсүгэй:

“10/Соёлын яам;”

2 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

8/Боловсрол, шинжлэх ухааны яам;

3 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 10, 11, 12, 13 дахь заалтын дугаарыг “11, 12, 13, 14” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2020 оны 7 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 13 дахь заалт нэмсүгэй:

“13/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Соёлын сайд;”

2 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:



“11/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Боловсрол, шинжлэх ухааны сайд,”

3 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 13, 14, 15, 16 дахь заалтыг дугаарыг “14, 15, 16, 17” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2020 оны 7 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 15¹ дүгээр зүйлийн 15¹.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“15¹.2. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын даргыг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18³ дугаар зүйлд заасан журмын дагуу томилж, чөлөөлнө.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2020 оны 7 дугаар сарын 07-ны өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Биеийн тамир, спортын тухай хуулийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.1.6, 6.1.7 дахь заалт нэмсүгэй:



“6.1.6. тухайн жилд Монгол Улсад зохион байгуулах олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээний жагсаалтыг батлах;

6.1.7. энэ хуулийн 6.1.4, 6.1.5, 10.1.4-т заасан тэмцээн, наадмыг зохион байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам батлах;”

2 дугаар зүйл. Биенийн тамир, спортын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “спортын” гэсний дараа “асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Биенийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“10 дугаар зүйл. Биенийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

10.1. Биенийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1. биенийн тамир, спортын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах;

10.1.2. биенийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллага, холбогдох бусад байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, иргэн, аж ахуй нэгж, байгууллагатай хамтран ажиллах;

10.1.3. бие бялдрын түвшин тогтоох стандартыг боловсруулан, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 9.1-д заасны дагуу батлуулж, улсын бүртгэлд бүртгүүлэх;

10.1.4. улсын төсвөөс санхүүжүүлэх улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах спортын холбоог сонгон шалгаруулах;

10.1.5. улсын хэмжээнд зохион байгуулах спортын наадмын хөтөлбөрт багтах спортын төрлийг тогтоох, тэмцээний зохион байгуулалтыг арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих;

10.1.6. эрхэлсэн сайдын баталсан биенийн тамирын арга зүйчид мэргэжлийн зэрэг олгох журмын хэрэгжилтийг хангах;

10.1.7. эрхэлсэн сайдын баталсан улсын төсвөөс дэмжлэг үзүүлэх үндэсний шигшээ багийг бүрдүүлэх, спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журмын хэрэгжилтийг хангах;



10.1.8.биеийн тамир, спортын мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлэх;

10.1.9.хүн амд эрүүл аж төрөх зан үйлийг хэвшүүлэх, иргэнийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх ажлыг зохион байгуулах;

10.1.10.бие бялдрын түвшин тогтоох сорилыг улсын хэмжээнд зохион байгуулах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

10.1.11.допингийн эсрэг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

10.1.12.энэ хуульд заасан өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж, холбогдох зардлыг санхүүжүүлэх;

10.1.13.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.”

4 дүгээр зүйл.Биеийн тамир, спортын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалтын дугаарыг “6.1.8” гэж өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Биеийн тамир, спортын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсэг, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийн “төв” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Биеийн тамир, спортын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг 2020 оны 7 дугаар сарын 07-ны өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсгийн “соёл,” гэснийг хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2020 оны 7 дугаар сарын 07-ны өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.22 дахь хэсэг нэмсүгэй:

“15.22.Соёлын чиглэлээр:

15.22.1.түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлсийг улсын хилээр нэвтрүүлэх;

15.22.2.соёлын өвийг сэргээн засварлах, палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх.”

2 дугаар зүйл.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“15.7.Боловсрол, шинжлэх ухааны чиглэлээр:

15.7.1.их сургууль, дээд сургууль, коллежийн үйл ажиллагаа эрхлэх;

15.7.2.магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэх;
15.7.3.дээд боловсролын шинэ мэргэжлээр сургалт явуулах;

15.7.4.мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагаа эрхлэх;



15.7.5. мэргэжлийн боловсрол, сургалтын шинэ мэргэжлээр сургалт явуулах;

15.7.6. гадаад улсад боловсрол эзэмшүүлэх, сургалтад хамруулахад зуучлах үйлчилгээ;

15.7.7. олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургууль болон ерөнхий боловсролын лаборатори сургуулийг байгуулах;

15.7.8. гадаадын хөрөнгө оруулалттай цэцэрлэг, сургууль байгуулах.”

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2020 оны 7 дугаар сарын 07-ны өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 22¹ дүгээр зүйл нэмсүгэй:

“22¹ дүгээр зүйл. Соёлын чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

22¹.1. Соёлын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

22¹.1.1. түүх, соёлын хосгүй үнэт зүйлийг бүртгэх, гэрчилгээ олгоход 1000-2000 төгрөг;

22¹.1.2. хот, суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул

хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгоход археологи, палеонтологийн мэргэжлийн байгууллагаар урьдчилан судалгаа хийлгэж, түүнээс зөвшөөрөл олгоход 40 000-300 000 төгрөг;

22¹.1.3.соёлын өвийг хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгоход 20 000-50 000 төгрөг, шаардлагатай бол хугацааг сунгахад 12 000-30 000 төгрөг.

22¹.1.4.соёлын өвийг сэргээн засварлах, палентологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрөл олгоход 300 000-500 000 төгрөг.”

2 дугаар зүйл.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“22 дугаар зүйл.Боловсрол, шинжлэх ухааны чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

22.1.Боловсрол, шинжлэх ухааны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

22.1.1.их сургууль, дээд сургууль, коллеж байгуулах тусгай зөвшөөрөл олгоход 400 000-1 000 000 төгрөг;

22.1.2.мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх богино хугацааны мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт эрхлэх зөвшөөрөл олгоход 160 000-400 000 төгрөг;

22.1.3.магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 200 000-500 000 төгрөг, зөвшөөрлийг сунгахад 20 000-50 000 төгрөг;

22.1.4.дээд боловсролын байгууллага шинэ мэргэжлээр бакалаврын сургалт явуулах тусгай зөвшөөрөл олгоход 120 000-300 000 төгрөг;

22.1.5.мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага байгуулах тусгай зөвшөөрөл олгоход 160 000-400 000 төгрөг;

22.1.6.мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад шинэ мэргэжлээр сургалт явуулах тусгай зөвшөөрөл олгоход 60 000-150 000 төгрөг;



22.1.7.боловсролын магадлан итгэмжлэл олгоход 105 000-260 000 төгрөг;

22.1.8.дахин магадлан итгэмжлэл олгоход 35 000-85 000 төгрөг;

22.1.9.улсын хэмжээнд үйлчилгээ үзүүлдэг ерөнхий боловсролын сургууль байгуулах зөвшөөрөл олгоход 26 000-65 000 төгрөг.”

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2020 оны 7 дугаар сарын 07-ны өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7.1 дэх заалтын “эрхэлсэн” гэсний дараа “төрийн захиргааны байгууллага” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.2, 7.3 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.3.9 дэх заалт, 9.4 дэх хэсэг, 9.6.2, 9.6.3, 9.6.4, 9.7.2, 9.8.2, 9.10.1, 9.10.2, 9.10.3, 9.11.1, 9.12.2, 9.12.5, 9.12.7, 9.12.8 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.7 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.1, 22.4, 22.5 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “төв” гэснийг, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсгийн “хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэсний “төв” гэснийг, 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “Монгол Улсын Шадар сайдын тэргүүлсэн” гэснийг тус тус хассугай.



3 дугаар зүйл.Энэ хуулийг 2020 оны 7 дугаар сарын 07-ны өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн шадар сайд, орлогч дарга нь” гэснийг, 6.5 дахь хэсгийн “төв” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2020 оны 7 дугаар сарын 07-ны өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 07 дугаар
сарын 01-ний өдөр

Дугаар 04

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын дэд дарга нарыг сонгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, 17 дугаар зүйлийн 17.3.4 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 25 дугаар зүйл, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:



1. Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс нэр дэвшүүлсэн Улсын Их Хурлын гишүүн Төмөрбаатарын Аюурсайхан, Ардчилсан намын бүлгээс нэр дэвшүүлсэн Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтуяа нарыг Монгол Улсын Их Хурлын дэд даргаар тус тус сонгосугай.

2. Энэ тогтоолыг 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 07 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар
хот

Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, 28.3 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Ерөнхий сайдаар Ухнаагийн Хүрэлсүхийг томилсугай.

2. Энэ тогтоолыг 2020 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 07 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 06

Улаанбаатар
хот

Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.5 дахь, 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалт болон 28.6 дахь хэсэг, Монгол

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

- 1.Нямаагийн Энхболд
- 2.Сүхбаатарын Батболд
- 3.Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ
- 4.Сандагийн Бямбацогт
- 5.Цэндийн Мөнх-Оргил

2.Энэ тогтоолыг 2020 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар
хот

Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 12 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тогтоолыг 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



Монгол Улсын Их Хурлын 2020 оны
07 дугаар тогтоолын хавсралт

**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО,
БҮТЦИЙН ЕРӨНХИЙ БҮДҮҮВЧ**

Эрхлэх асуудлын хүрээ, харьяалал	Засгийн газрын тохируулагч агентлаг	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд	1.Тагнуулын ерөнхий газар 2.Төрийн тусгай хамгаалалтын газар 3.Биеийн тамир, спортын улсын хороо	1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд	4. М э р г э ж л и й н хяналтын ерөнхий газар 5.Онцгой байдлын ерөнхий газар 6.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар 7.Стандарт, хэмжил зүйн газар	2.Төрийн худалдан авах ажиллагааны газар
Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээнд	8.Харилцаа холбоо, м э д э э л л и й н технологийн газар 9.Үндэсний хөгжлийн газар	
Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээнд		3.Цаг уур, орчны шинжилгээний газар 4.Усны газар
Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнд	10.Зэвсэгт хүчний жанжин штаб	
Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд		
Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		5.Гаалийн ерөнхий газар 6.Татварын ерөнхий газар
Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд	11. Ц а г д а а г и й н ерөнхий газар 12.Хил хамгаалах ерөнхий газар	7.Улсын бүртгэлийн ерөнхий газар 8.Архивын ерөнхий газар 9.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар 10.Гадаадын иргэн, харьяатын газар 11.Оюуны өмчийн газар



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд		12.Нийгмийн даатгалын ерөнхий газар 13.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар 14.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар 15.Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд		16.Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар
Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд		
Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		17.Иргэний нисэхийн ерөнхий газар
Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээнд		18.Соёл, урлагийн газар
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		19.Ашигт малтмал, газрын тосны газар 20.Үндэсний геологийн алба
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		21.Мал эмнэлгийн ерөнхий газар 22.Жижиг, дунд үйлдвэрийн газар
Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээнд		
Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		23.Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 08

Улаанбаатар
хот

Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг томилох тухай” Монгол Улсын Их Хурлын 2017 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 58 дугаар, “Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох тухай” Монгол Улсын Их



Хурлын 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 05 дугаар, “Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг томилох тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 25 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2.Энэ тогтоолыг 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 05 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 44

Улаанбаатар
хот

**Элчин сайдыг эгүүлэн татах,
тохоон томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Армени Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Банзрагчийн Дэлгэрмааг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Армени Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дуламсүрэнгийн Давааг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 05 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 45

Улаанбаатар
хот

**Элчин сайдыг эгүүлэн татах,
тохоон томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Чили Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Чулуунбаатарын Сосормааг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Чили Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Шагдарын Батцэцэгийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 05 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 46

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Аргентин Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Чулуунбаатарын Сосормааг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Аргентин Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Шагдарын Батцэцэгийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 05 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 47

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Эстони Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Мэндсайханы Энхсайханыг эгүүлэн татаж, Монгол



Улсаас Бүгд Найрамдах Эстони Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Түвшиндоржийн Жанабазарыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 05 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 48

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Латви Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Нэмэхийн Батааг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Латви Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Бархасын Доржийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 483

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн 6.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, ажлын үр дүнг 2021 оны II улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзоригт даалгасугай.



3. Энэ тогтоолыг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

С.ЧИНЗОРИГ

Засгийн газрын 2019 оны
483 дугаар тогтоолын хавсралт

**МАЛЧИН, ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ ИРГЭНИЙ ТЭТГЭВРИЙН
ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуульд заасан болзол, нөхцөлийн дагуу малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн (цаашид “иргэн” гэх)-ий 1995 оноос 2019 оныг дуустал хугацааны төлөгдөөгүй тэтгэврийн даатгалын шимтгэл (цаашид “шимтгэл” гэх)-ийг нэг удаа нөхөн төлүүлэх, орлогыг төвлөрүүлэх, мэдээллийн нэгдсэн санд бүртгэх, тайлагнах, шимтгэл нөхөн төлсөн хугацааг хянан баталгаажуулахад энэ журмыг мөрдөнө.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн 4.1 дэх хэсэгт заасан, нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн сангаас өндөр насны тэтгэвэр, цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгоогүй, 1995-2019 онд малчнаар ажилласан болон хувиараа хөдөлмөр эрхэлж байхдаа шимтгэл төлөөгүй 15-60 насны Монгол Улсын иргэний шимтгэлийг нөхөн төлүүлнэ.

Гурав. Шимтгэлийн хэмжээ, шимтгэл төлөх

3.1. Иргэний нэг сарын нөхөн төлөх шимтгэлийн хэмжээ нь Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн 5.1 дэх хэсэгт заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооноос 2020 онд мөрдүүлэхээр баталсан сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (420 000 төгрөг)-ний 10 хувь буюу сард 42 000 (дөчин хоёр мянган) төгрөг байна.

3.2. Иргэн энэ журмын 3.1-д заасны дагуу шимтгэлийг нөхөн төлөх сарын тоогоор үржүүлж тооцсон нийт шимтгэлийг нийгмийн даатгалын сангийн холбогдох дансанд нэг удаа бүрэн төлнө.



Дөрөв. Иргэн хүсэлт гаргах, шимтгэл нөхөн төлөх хугацааг тодорхойлох

4.1. Иргэн нь шимтгэл нөхөн төлөх хүсэлтээ өөрийн харьяалагдах үндсэн болон түр оршин суугаа газрын харьяа нийгмийн даатгалын байгууллагад 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор энэ журамд заасны дагуу холбогдох баримт бичгийн хамт гаргана.

4.2. Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллага малчнаар ажилласан жилийг тодорхойлохдоо Засгийн газраас баталсан малчинд тэтгэвэр тогтооход баримтлах журмын холбогдох заалтыг мөрдөж шимтгэл нөхөн төлүүлж ажиллана.

4.3. Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллага хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэнээр шимтгэл нөхөн төлүүлэхдээ нөхөн төлөх сар, жилд хувь хүний орлогын албан татвар төлөгчөөр бүртгэгдсэн болон уг татварыг төлж байсан тухай татварын төв байгууллагаас тодорхойлсон баримт бичгийг үндэслэнэ.

4.4. Иргэн шимтгэл нөхөн төлөх хугацааг өөрийн санхүүгийн боломж, энэ журмын 4.3-т заасантай нийцүүлэн дараах байдлаар сонгож болно:

4.4.1. энэ журмын 2.1-д заасан бүх хугацааны доторх шимтгэл төлөөгүй бүх жилүүд, эсхүл өөрийн хүсэлтээр сонгосон жилүүд;

4.4.2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан шимтгэл төлсөн байвал зохих хугацааг хангахад шаардагдах жилүүд.

4.5. Нийгмийн даатгалын байгууллага энэ журмын 4.4-т заасан нөхөн төлөх хугацааг сонгоход иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч хамтран ажиллана.

4.6. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн 4.2, 4.3 дахь хэсэгт заасны дагуу тухайн иргэний малчнаар ажилласан болон хувиараа хөдөлмөр эрхлэгч байсан хугацаанд хамаарахгүй хугацаа, хорих ял биеэр эдэлсэн хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэхгүй.

Тав. Шимтгэл нөхөн төлөх хугацааг баталгаажуулахад төрийн байгууллагатай хамтран ажиллах

5.1. Нийгмийн даатгалын төв байгууллага нь иргэний шимтгэл нөхөн төлөх хугацааг бодитой тодорхойлох зорилгоор холбогдох төрийн байгууллагатай хамтран ажиллана.

5.2. Нийгмийн даатгалын төв байгууллага нь татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай дараах байдлаар хамтран ажиллана:

5.2.1. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд шууд хамааралтай хувь хүний орлогын албан татварт хамаарах татварын ангиллыг хамтран тодорхойлох;

5.2.2. Энэ журмын 5.2.1-д заасныг үндэслэн 1995-2019 оны хувь хүний орлогын албан татвар төлөгчөөр бүртгэлтэй байсан тухайг тодорхойлох мэдээллийн нэгдсэн санг татварын ангилал тус бүрээр үүсгэж, нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллага ашиглах боломжийг бүрдүүлэх;

5.2.3. Хувь хүний орлогын албан татварын төлөгчийн болон татвар төлсөн тухай бүртгэл мэдээллийн нэгдсэн сангаас хувиараа хөдөлмөр эрхлэгчийн шимтгэл нөхөн төлөх онуудад хувь хүний орлогын албан татвар төлж байсан тухай тодорхойлолтыг нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллага цахим хэлбэрээр ашиглах, хянах, харах, хэвлэх боломжоор хангах.

5.3. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, харьяа бусад байгууллага нь иргэний шимтгэл нөхөн төлөх онуудад ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургууль, коллежийн өдрийн ангид суралцсан эсэхийг тодорхойлоход шаардагдах мэдээллийг цахим болон цаасан хэлбэрээр солилцож хамтран ажиллана.

5.4. Цагдаагийн ерөнхий газар нь иргэний шимтгэл нөхөн төлөх онуудад хорих ял биеэр эдэлж байсан эсэх мэдээллийг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар нь иргэний хоригдож байгаа эсэх тухай мэдээллийг цахим болон цаасан хэлбэрээр нийгмийн даатгалын төв байгууллагатай тус тус солилцож хамтран ажиллана.

Зургаа. Шимтгэл нөхөн төлөхөд бүрдүүлэх баримт бичиг, тэдгээрийг хадгалах

6.1. Иргэн шимтгэл нөхөн төлөхдөө Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан баримт бичгийг бүрдүүлж, харьяалах нийгмийн даатгалын байгууллагад ирүүлнэ.

6.2. Нийгмийн даатгалын байгууллага нь энэ журмын 4.5-д заасны дагуу иргэний ажилласан болон шимтгэл төлсөн хугацааг бодитой



тогтооход туслах зорилгоор Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 7-д заасан баримт бичиг болон ажилласан хугацааг тогтоосон тухай шүүхийн шийдвэр, хугацаат цэргийн алба хаасан тухай цэргийн үнэмлэх, батлах, лавлагааг шаардлагатай тохиолдолд гаргуулан авч болно.

6.3. Нийгмийн даатгалын байгууллага шимтгэл нөхөн төлсөн иргэн бүрд хувийн хэрэг үүсгэн энэ журмын 5.2-5.4, 6.1-6.2-т заасан баримтыг бүрдүүлбэр болгон архивын хадгаламжийн нэгж болгон хадгална.

Долоо. Мэдээллийн нэгдсэн санд бүртгэх, баталгаажилтын хуудас олгох

7.1. Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс шимтгэлийг тэтгэврийн даатгалын санд бүрэн нөхөн төлсөн малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийг оршин сууж байсан болон оршин сууж байгаа сум (баг), дүүрэг (хороо)-ээр нь мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, тайланг сар бүр гаргаж, дараа сарын 5-ны өдрийн дотор цахим болон хэвлэмэл хэлбэрээр Нийгмийн даатгалын төв байгууллагад хүргүүлнэ.

7.2. Нийгмийн даатгалын төв байгууллага нь энэ журмын 7.1-д заасан тайланг хянан шалгасны үндсэн дээр энэ журмын хавсралтаар баталсан “Баталгаажилтын хуудас” (шимтгэлийг нөхөн тооцсон тухай тэмдэглэлийн хамт)-ыг (цаашид “Баталгаажилтын хуудас” гэх) албажуулан сар бүрийн 30-ны өдрийн дотор холбогдох аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлнэ.

7.3. Нийгмийн даатгалын төв байгууллага нь энэ журмын 7.1, 7.2-т заасан тайлан, мэдээллийг улирал бүр гаргаж, улирлын дараа сарын 15-ны өдрийн дотор нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

7.4. Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь “Баталгаажилтын хуудас”-ыг малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн нийгмийн даатгалын дэвтэрт нааж, тамга, тэмдгээр баталгаажуулна.

7.5. “Баталгаажилтын хуудас” нь нийгмийн даатгалын дэвтрийн нэгэн адил хүчин төгөлдөр баримт бичиг байна.

7.6. Иргэн нь “Баталгаажилтын хуудас”-аа үрэгдүүлсэн тохиолдолд холбогдох нийгмийн даатгалын хэлтэс түүний хувийн хэрэг болон мэдээллийн нэгдсэн санд үндэслэн лавлагаа олгож болно.

7.7. “Баталгаажилтын хуудас”-ыг хуурамчаар үйлдэхийг хориглоно.



**Найм. Шимтгэл нөхөн төлсөн хугацааг
тэтгэвэр тогтооход баримтлах**

8.1. Шимтгэл нөхөн төлсөн иргэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан тэтгэвэр тогтоолгох нөхцөл, болзлыг хангаж шинээр тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан бол түүний шимтгэл нөхөн төлсөн хугацааг “Баталгаажилтын хуудас” олгогдсон өдрөөс эхлэн шимтгэл төлсөн нийт хугацаанд оруулан тооцно.

8.2. Шимтгэл нөхөн төлсөн хугацаа нь хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн, мэргэжлийн урлагийн байгууллага, төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалалтын албанд ажилласан, цэргийн алба хаасан хугацаанд хамаарахгүй.

Ес. Бусад

9.1. Иргэн шимтгэл нөхөн төлөх үйл ажиллагааг Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллага эрхлэн гүйцэтгэж, хяналт тавьж ажиллана.

9.2. Энэ журмыг хэрэгжүүлэх аргачлал, заавар болон иргэний шимтгэл нөхөн төлөх хүсэлтийн загварыг Нийгмийн даатгалын төв байгууллага баталж болно.

9.3. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль, энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

9.4. Энэ журмыг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл дагаж мөрдөнө.

Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 483 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”-ын хавсралт

БАТАЛГААЖИЛТЫН ХУУДАС №.....

Иргэн овгийн.....(эцэг/эхийн)-ийн..... (нэр) (РД.....) нь Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуульд заасан болзол, нөхцөлийн дагуу 1995 оноос хойш нийтдээ жил сар, үүнээс малчнаар жил сар тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлсөн болохыг баталгаажуулав.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга,
Нийгмийн даатгалын улсын ерөнхий байцаагч...../ /
2020 оны ... дугаар сарын -ны өдөр



.....тоот “Баталгаажилтын хуудас”-тай.....овгийн.....(эцэг/
эхийн)-ийн.....(нэр) (РД.....)-ний
тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлсөн тухай тэмдэглэл

Он	Сарууд												Нийт сарын тоо
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
1995													
1996													
1997													
1998													
1999													
2000													
2001													
2002													
2003													
2004													
2005													
2006													
2007													
2008													
2009													
2010													
2011													
2012													
2013													
2014													
2015													
2016													
2017													
2018													
2019													
Нийт жил, сар	(.....жил.....сар, санд төлсөн шимтгэл.....төгрөг)												

Тайлбар: Малчнаар ажиллаж, шимтгэл төлсөн хугацааг “М” үсгээр тэмдэглэнэ.

Хянаж баталгаажуулсан:

.....аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын

Хэлтсийн дарга...../ /

Санхүүгийн тасгийн дарга...../ /

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 484

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай хуулийн 2 дугаар зүйлд заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхэд баримтлах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг жил бүр улсын төсөвт тусгахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзоригт даалгасугай.

4. Энэ тогтоолыг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

С.ЧИНЗОРИГ

Засгийн газрын 2019 оны
484 дүгээр тогтоолын хавсралт

ЗАРИМ ИРГЭНИЙ ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасны дагуу Улсын Бага Хурлын 1990 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн баталсан БНМАУ-ын Тэтгэврийн хуульд заасан болзол, нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгосон зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэн тогтоох, хянахад энэ журмыг баримтална.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан иргэн хамаарна.



Гурав. Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх иргэний
мэдээллийг шалган бүртгэж, тэтгэврийг
нэмэгдүүлэн тогтоох

3.1. Нийгмийн даатгалын байгууллага нь Зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай хуулийн дагуу тэтгэвэр нь нэмэгдэх иргэдийн мэдээллийг тэтгэвэр авагчийн хувийн хэрэгт үндэслэн шалган баталгаажуулж, нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

3.2 Нийгмийн даатгалын байгууллага нь энэ журмын 3.1-д заасны дагуу шалгаж бүртгэсэн иргэний сарын тэтгэврийн хэмжээг 50000 (тавин мянган) төгрөгөөр нэмэгдүүлэн тогтооно.

Дөрөв. Бусад

4.1. Энэ журмын хэрэгжилтэд Нийгмийн даатгалын төв байгууллага хяналт тавьж, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

4.2. Зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай хууль, энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2020 оны 05 дугаар
сарын 06-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн
29 дүгээр зүйлийн 29.8 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн
32.2.9, 32.3.11 дэх заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг
зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн
хуралдааны танхим 16.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Б.Буяндэлгэр даргалж, гишүүн Д.Солонго /илтгэгч/, Г.Туулхүү, Ц.Нанзаддорж, Г.Баясгалан нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Мөнхгэрэлийг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд иргэн Г.Давааням, Л.Мөнхсайхан, Т.Баярхүү, С.Номынбаясгалан, Н.Чадраабал, Ё.Бямбатогтох, Ц.Шаравдорж болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайхан нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Гуравдугаар зүйлийн 1, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9, 10 дахь заалт, Арван есдүгээр зүйлийн 1, Хорин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн холбогдох заалтыг, мөн хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.9, 32.3.11 дэх заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт, Хорин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 11 дүгээр хорооны оршин суугч, иргэн Г.Давааням, Баянгол дүүргийн 3 дугаар хорооны оршин суугч, иргэн Н.Уламбаяр нар Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:

“1. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” гэснийг зөрчжээ. Энд сонгогчдын сонгох эрхийг, иргэний сонгогдох эрхийг давхар зөрчив. Сонгогчдын сонгохыг хүссэн хүнийг энэ хуулиар нэр дэвшүүлэхгүй байх магадлал өндөр болжээ.

Ял эдэлж байгаагаас бусад сонгуулийн насны Монгол Улсын иргэн Үндсэн хуулиар олгогдсон сонгох, сонгогдох эрхтэй байтал “авлига, албан тушаалын гэмт хэрэгт ял эдэлж байсан бол” хэмээн онцгойлон зааж иргэний “хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх” зарчмыг зөрчиж, ялгаварлан гадуурхаж, хүний сонгогдох эрхийг дордуулсан байна. Энэ заалт Үндсэн хуулийн “Эх орондоо хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно” гэсэн Үндсэн хуулийн эрхэм зорилгыг зөрчиж, хэлмэгдэл дүүрэн заалт болжээ.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтад “... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө ... хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг



хориглоно. ..." гэсэн заалтыг зөрчив. ... Энэхүү заалтаас харахад хүн амины хэрэг, хүчингийн хэрэг, мөнгө угаасан хэрэг, ЖДҮ-дсэн улс төрчид, эх орноосоо урвасан хэрэгт шүүхээр ял эдэлсэн хүмүүс Улсын Их Хуралд нэр дэвших эрхтэй харагдаж байна. Харин авлига, албан тушаалын хэрэгт ял эдэлсэн бол ялгаварлан гадуурхагдаж байна. ...

3. Хууль санаачлагчид Төрийн албаны хууль давлига, албан тушаалын хэргээр шүүхээс ял эдэлсэн хүнийг төрийн албанд ажиллуулахгүй гэсэн заалт орсон гэж тайлбарлаж байгаад Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8 дахь хэсгийг оруулсан. Улсын Их Хурлын гишүүн бол сонгогддог улс төрийн алба. Төрийн захиргааны албан тушаалтан бол томилогддог албан тушаалтан. Иймд сонгогддог Улсын Их Хурлын гишүүнд томилогддог төрийн албан тушаалтны хууль эрх зүйн зохицуулалтыг хэрэглэж болохгүй гэдэг нь ойлгомжтой.

4. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэснийг зөрчлөө. Төрөөс хүний зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгаа бүрдүүлэхийг иргэнийхээ өмнө хариуцах үүрэг хүлээсэн байтал Улсын Их Хурал маань иргэнээ хэлмэгдүүлж ялгаварлан гадуурхаж сонгогдох эрхэд нь халджээ. ...

5. Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралт хуулийн Долдугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан "Монгол Улсын Үндсэн хуульд тодорхойлсон хүний эрхийг дордуулсан заалт бүхий ... хууль болон олон улсын гэрээ, тэдгээрийн заалтыг мөнхүү Үндсэн хууль хүчин төгөлдөр болсноос хойш хэрэглэхийг хориглоно. ..." гэсэн заалтыг зөрчиж иргэний сонгогдох эрхийг насан туршид хассан байна. ...

6. ... Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын "Хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй. ..." гэсэн заалтын хүний сонгох, сонгогдох халдашгүй дархан байх эрхэд халдав. Тус Пактын 25 дугаар зүйлийн "Иргэн бүр 2 дугаар зүйлд дурдсан аливаа алагчилалгүйгээр болон үндэслэлгүй хязгаарлалтгүйгээр дараах эрх, боломжийг эдэлнэ: ... (b) сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хурааж, сонгогчид жинхэнэ хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг баталгаажуулсан, жинхэнэ ёсоор тогтмол явагддаг сонгуульд сонгох буюу сонгогдох;" гэснийг зөрчин алагчлан хязгаарлаж сонгогдох эрхэд халдан хэлмэгдүүлж олон улсын Пактад заасан хүний эрхийг зөрчжээ.

Монгол Улсын хууль, олон улсын гэрээ хэлэлцээрийг зөрчсөн бол олон улсын гэрээ хэлэлцээрийг дагах хууль бий. Пактын 2 дугаар зүйлийн 1-д “Энэхүү Пактад оролцогч улс бүр нутаг дэвсгэртээ болон харьяалалдаа байгаа бүх хүний энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, ... бусад байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах үүрэгтэй.” гэсээр байтал үүнийг үл хүндэтгэн улс төрийн зорилгоор сонгуулийн хуульд эрүүгийн хуулийн заалт оруулж, олон улсын хүний эрхийн Пактаар хүлээн зөвшөөрсөн хүний эрхийг маш бүдүүлгээр зөрчиж хүний эрхийг дордуулан насан туршид сонгогдох эрхийг хясан боогдуулж хэлмэгдүүлж байна. ...

Иймд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8 дахь хэсэгт “Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно.” гэсэн нь иргэний сонгогдох эрхийг хязгаарласан, Үндсэн хууль зөрчсөн зөрчлийг нэн даруй залруулж өгнө үү.” гэжээ.

Хоёр. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 8 дугаар хорооны оршин суугч, иргэн Л.Мөнхсайхан, Хан-Уул дүүргийн 11 дүгээр хорооны оршин суугч, иргэн Т.Баярхүү нар Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“1. Сонгуулийн хуулиар ... иргэд нийтээрээ оролцох, шууд сонгох эрхтэй, иргэний сонгогдох эрхийг зөвхөн насаар хязгаарлах тухай, мөн сонгуулийн хуулиар эрүүгийн хариуцлага оногдуулах харилцааг биш харин сонгуулийн журмыг тогтоодог тухай Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлд тусгасан байна.

... Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн “Нэр дэвшүүлэх нийтлэг журам” гэсэн 29 дүгээр зүйлийн 29.8 дахь хэсэгт “Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно.” гэж заасан нь сонгуулийн үйл ажиллагаа зохион байгуулж явуулахад мөрдөх “сонгуулийн үйл ажиллагааны журам тогтоосон” биш, харин “нэмэгдэл ял оногдуулах” шинжтэй болсон нь иргэний сонгогдох эрхийг гагцхүү насаар хязгаарлах тухай Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно.”, “Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн. ...

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар иргэний төрийн байгууллагад сонгох, сонгогдох харилцааг, өөрөөр хэлбэл, Үндсэн хуульд



заасан иргэний эрхээ эдлэх эрх зүйн шинжтэй харилцааг зохицуулсан байтал Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8 дахь хэсэгт “Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно.” гэж “Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвших эрхийг хасах ял”-ыг сонгуулийн хуулиар оногдуулах, энэ ялыг оногдуулах эрхийг сонгуулийн төв байгууллага эдлэх, зарим төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд “эрх хасах” нэмэгдэл ял оноох тухай заасан нь уг хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулах үндсэн зарчим, журмыг тодорхойлж, түүнтэй холбогдсон харилцааг зохицуулах, Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангахад оршино.” гэсэн зорилтоос хазайж, эсрэгээрээ иргэний сонгогдох төдийгүй сонгох эрхийг хангах биш хааж боогдуулсан явдал бөгөөд ингэснээр Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 1.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Гэмт хэрэг, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг энэ хуулиар тодорхойлно.”, мөн хуулийн 5.2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Энэ хуулийн тусгай ангид гэмт хэрэгт оногдуулах үндсэн ялын төрөл, хэмжээг заана.”, 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүх гэмт хэрэг үйлдсэн хүнд энэ хуулийн ерөнхий ангид заасан үндэслэл, журмын дагуу тусгай ангид заасан төрөл, хэмжээний дотор эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.” гэсэн заалтуудтай зөрчилдсөн, улмаар Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.”, 2 дахь хэсгийн “Ямар ч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно.” гэснийг зөрчсөн байна. ...

Энэ талаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2008 онд гарсан 06 дугаар дүгнэлт хүчин төгөлдөр үйлчилж байхад Улсын Их Хурал дахин Үндсэн хууль зөрчсөн хууль баталсан нь Үндсэн хуульд тунхагласан “төрийн үйл ажиллагаанд хууль дээдлэх зарчим”-ыг уландаа гишгэсэн явдал юм. ... Уг дүгнэлтийн үндэслэл хэсгийн 2-т “Хууль тогтоогч Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэр дэвшигчид тавих шаардлагад “Ялгүй байх” гэсэн заалтыг оруулснаараа ялгүйд тооцох гэсэн ойлголтоос агуулгын хувьд өөрчлөгдөж Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээдийн улс төрийн эрх буюу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох эрхийг ял шийтгүүлсний дараа бүх насаар нь хязгаарлаж байгаагаараа Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулсан байна.” гээд тус дүгнэлтийн тогтоох хэсгийн 1-д “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсэгт “Нэр дэвшигч нь ... дараах шаардлагыг хангасан байна” гээд 27.4.3 дахь заалтад “ялгүй

байх” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...”, Хорин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.” хэмээжээ. ...

Үүнээс үзвэл Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8 дахь хэсгийн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй.”, Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Ямар ч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно.” гэснийг тус тус зөрчсөн байна. ...” гэсэн мэдээллийг ирүүлсэн байна.

Гурав. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 6 дугаар хорооны оршин суугч, иргэн С.Номынбаясгалан Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:

“... Монгол Улсын Үндсэн хуульд төрийн байгууллагад “сонгогдох” эрхийг зөвхөн хуулиар насны хязгаарлалт тогтоохоор зохицуулсан байтал Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар нэр дэвшигчид авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглох тухай Үндсэн хуульд тусгагдаагүй шаардлага тавьснаар Үндсэн хуулийн үзэл баримтлал, агуулгаас хальж, дурдсан гэмт хэрэгт өмнө нь ял шийтгүүлж байсан иргэдийн сонгуулийн эрх буюу “сонгогдох” үндсэн эрхийг хязгаарласан байна. Энэ нь тэдний “улс төрийн эрх” буюу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох эрхийг ял шийтгүүлсний дараа бүх насаар нь хязгаарлах хууль зүйн үр дагаврыг бий болгож байгаагаараа Үндсэн хуульд нийцэхгүй байна.

Иймд Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8 дахь хэсгийн “Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно.” гэсэн



нь, энэ хуулийн 32 дугаар зүйлд “Нэр дэвшүүлсэн нам, эвсэл нь нэр дэвшүүлэх ажиллагааны талаарх хуульд заасан хугацаа дууссан өдрөөс хойш тав хоногт багтаан дараах баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.” гээд 32.2.9 дэх заалтад “авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаарх холбогдох байгууллагын лавлагаа.”, мөн зүйлийн 32.3 дахь хэсгийн 32.3.11 дэх заалтад “авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаарх холбогдох байгууллагын лавлагаа.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...”, энэ хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно.” гэснийг тус тус зөрчсөн тул хянан хэлэлцэж дүгнэлт гаргаж өгнө үү.” гэжээ.

Дөрөв. Нийслэлийн Баянгол дүүргийн 2 дугаар хорооны оршин суугч, иргэн Н.Чадраабал, Налайх дүүргийн 7 дугаар хорооны оршин суугч, иргэн Ё.Бямбатогтох нар Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“ ... Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8 дахь хэсэгт “Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно.” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” ... гэснийг зөрчиж байна. Энэ асуудлаарх Үндсэн хуулийн цэцийн 2008 оны сонгуулийн хуулиар дамжуулан иргэний Үндсэн хуулиар олгогдсон сонгох, сонгогдох эрхэнд халдаж болохгүй гэсэн агуулгатай 06 дугаар дүгнэлт хүчин төгөлдөр үйлчилж байгааг мэдсээр байж Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд дээрх заалтыг оруулж баталсан нь тодорхой нэг хүний эсрэг чиглэсэн хандлагатай үйл ажиллагаа болж байна гэж Улсын Их Хурлын чуулганы хуралдаан дээр зарим гишүүд ярьж байсныг үндэслэлтэй гэж үзэж байна. Энэ бол Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... шударга ёс, ... тэгш байдал ... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал, ... үзэл бодол ...-оор нь ялгаварлан гадуурхаж үл болно. ”, Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтад “... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. ...” гэж заасныг тус тус зөрчиж байна. ...” гэсэн мэдээллийг ирүүлсэн байна.

Тав. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны оршин суугч, иргэн Ц.Шаравдорж, Баянгол дүүргийн 2 дугаар хорооны оршин суугч, иргэн Д.Шонхоо нар Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:

“... Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8 дахь хэсэгт “Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн “Сонгох, сонгогдох” эрхийг зөрчөөд зогсохгүй, Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 06 дугаар дүгнэлтийн үндэслэх хэсэгт “Хууль тогтоогч Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэр дэвшигчид тавих шаардлагад “Ялгүй байх” гэсэн заалтыг оруулснаараа ялгүйд тооцох гэсэн ойлголтоос агуулгын хувьд өөрчлөгдөж Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээдийн улс төрийн эрх буюу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох эрхийг ял шийтгүүлсний дараа бүх насаар нь хязгаарлаж байгаагаараа Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулсан байна.” гээд “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсэгт “Нэр дэвшигч нь ... дараахь шаардлагыг хангасан байна” гээд 27.4.3 дахь заалтад “ялгүй байх” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...”, Хорин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.” гэж дүгнэснийг Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцийн энэхүү дүгнэлтийг хүлээн авч, хүний “сонгогдох эрх”-ийг зөрчсөн заалтыг хүчингүй болгосон. Гэтэл Үндсэн хуулийн цэцийн энэ дүгнэлт одоог хүртэл хүчин төгөлдөр байгааг үл хайхарч, Үндсэн хууль зөрчсөн заалтыг илтэд санаатайгаар дахин оруулж ирж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуульд халдсан бусармаг явдал, төрийн эсрэг гэмт хэргийн шинжтэй санаатай үйлдэл гэж үзэхээс аргагүй байна. ...

Авлига, албан тушаалын хэрэг ноцтой ч, иргэдийн амь бие, аюулгүй байдал, төрийн тусгаар байдалд нэн хор аюул учруулдаг хүн амь, хүчин, дээрэм, эх орноосоо урвах, төрийн нууцыг задруулах мэт олон хэргүүдийг авч үзээгүй, Монгол Улсыг саарал жагсаалтад оруулсан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, эх үүсвэрээ тогтоож чаддаггүй асар их мөнгө, валют, хар тамхины хэргүүдийг огт дурдахгүй, ганцхан “албан тушаалын” гэх хэргийг онцолж байгаа нь дээрх дүгнэлтийг хийхэд хүргэж байна. ...

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар



зүйлийн 9 дэх заалтын холбогдох хэсгийг зөрчиж байгаа тул уг заалтыг хүчингүй болгож шийдвэрлэж өгнө үү.” гэжээ.

Зургаа. Уг маргаанд холбогдуулан Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайхан Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн хариу тайлбарт:

“Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8 дахь хэсэгт “Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно.”, 32 дугаар зүйлийн 32.2.9 дэх заалтад “авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаарх холбогдох байгууллагын лавлагаа.”, 32.3.11 дэх заалтад “авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаарх холбогдох байгууллагын лавлагаа.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй гэж үзэн дараах үндэслэлийг гаргаж байна.

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх нь Төрийн сүлдэндээ тангараг өргөснөөр эхэлж, Улсын Их Хурлын дараагийн сонгуулиар шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөснөөр дуусгавар болно.” гэж, түүнчлэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт “Гишүүн “Монгол Улсын Их Хурлын гишүүн би ард түмнийхээ элчийн хувьд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн, төрийн хуулийг дээдлэн сахиж, гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая” хэмээн төрийн сүлдэнд тангараг өргөнө.” гэж заасан. Улсын Их Хурлын гишүүн нь нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэгч болохын хувьд авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх нь хуульт ёсны шаардлага юм.

Өөрөөр хэлбэл, авлига, албан тушаалын гэмт хэргийг санаандгүй, болгоомжгүйгээр үйлддэггүй бөгөөд уг гэмт үйлдлийн цаана иргэд, олон нийт, улс орны язгуур эрх ашигт хор хохирол учруулж байдаг. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд уг хязгаарлалтыг хийсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлд заасан “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” гэсэн хүний эрхийн суурь зарчмыг хөндөөгүй болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.” гэж, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ.” гэж Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийг заасан бөгөөд Улсын Их Хурал энэ бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэрлэсэн нь Үндсэн хуулийн зөрчил биш юм.

Хууль тогтоогчид хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг батлахдаа Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай нийцэж байгаа эсэх уг асуудлаар урьд өмнө нь Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гарч байсан эсэхийг нягтлан тал бүрээс нь бүрэн дүүрэн судалж, олон шат дарааллын дагуу хэлэлцэн баталдаг.

Улсын Их Хурлаас 2005 онд баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэр дэвшигчдэд “ялгүй байх” гэсэн шаардлага тавигдаж байсныг Үндсэн хуулийн цэц 2008 оны 06 дугаар дүгнэлтээр Үндсэн хууль зөрчсөн гэсэн шийдвэр гаргасныг Улсын Их Хурал хүлээж авсан. Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг хүлээж авах үндэслэл нь тухайн этгээдийг насанд хүрээгүй байхдаа болон болгоомжгүй, санамсаргүйгээр гэмт хэрэг үйлдсэн, түүнчлэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг нь үл харгалзан бүгдийг хамруулсан нь буруу байна гэж үзэн Цэцийн шийдвэрийг хүлээж авах нь зүйтэй гэж хууль тогтоогчид үзсэн байдаг.

Түүнчлэн 2008 оны 06 дугаар дүгнэлтийн үндэслэх хэсгийн 2-т “Хууль тогтоогч Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэр дэвшигчид тавих шаардлагад “Ялгүй байх” гэсэн заалтыг оруулснаараа ялгүйд тооцох гэсэн ойлголтоос агуулгын хувьд өөрчлөгдөж ... байна.” гэсэн үндэслэлийг гаргаж байсан бөгөөд хэрэв Улсын дээд шүүх 2008 оны 16 дугаар тогтоолдоо “Ялгүй байх” гэсэн тайлбартаа ялгүйд тооцох гэсэн агуулгыг багтаасан бол зөрчил гэж үзэхгүй байхаар ойлгогдож байгаа юм. Өөрөөр хэлбэл, тодорхой хугацааны дараа ялгүйд тооцон дахин сонгуульд оролцож болох нөхцөл нь Үндсэн хуулийн зөрчил биш гэж үзвэл тодорхой гэмт хэргийн тухайд ч ийм хязгаарлалт тогтоох нь Үндсэн хуулийн зөрчил биш юм.

2. Монгол Улс 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Авлигын эсрэг конвенцид нэгдэн орсон бөгөөд 2005 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хурлаас соёрхон баталсан.



Тус конвенцийн зорилго нь авлигын эсрэг үр ашигтай бөгөөд үр дүнтэйгээр урьдчилан сэргийлж, тэмцэх арга хэмжээг хөхиүлэн дэмжиж, бэхжүүлэх гэж заасан байдаг бөгөөд конвенцийн 7 дугаар зүйлд “Оролцогч улс бүр нийтийн албан тушаалд нэр дэвших, сонгох шалгуурыг тогтоох зорилгоор хууль тогтоох болон захиргааны зохих арга хэмжээг энэхүү конвенцийн зорилт болон дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн авах асуудлыг мөн авч үзнэ.” гэж заасан байдаг.

Конвенцид оролцогч улсууд авлига нь нийгмийн тогтвортой болон аюулгүй байдалд үүсч буй бэрхшээл, аюул занал нь ардчилсан тогтолцоо, үнэт зүйлс, түүнчлэн ёс зүйн үнэт зүйлс, шударга ёсыг сулруулж, тогтвортой хөгжил, хууль дээдлэх ёсонд хохиролтой, бусад гэмт хэрэг, тухайлбал зохион байгуулалттай гэмт хэрэг, мөнгө угаах зэрэг эдийн засгийн гэмт хэрэгтэй холбоотой, улсын нөөц баялгийн тодорхой хэсгийг бүрдүүлэхүйц их хэмжээний хөрөнгөтэй холбоотой байдаг бөгөөд энэ нь тухайн улсын улс төрийн тогтвортой байдал, тогтвортой хөгжилд заналхийлж байдгаас гадна үндэсний хүрээнээс хальж бүх улс, эдийн засагт нөлөөлөхүйц үндэстэн дамнасан үзэгдэл болсноор түүнээс урьдчилан сэргийлж, хянахад олон улсын хамтын ажиллагаа зайлшгүй чухал болохыг тодорхойлж хүлээн зөвшөөрсөн байдаг.

“Авилгалтай тэмцэхийн тулд оролцогч улс бүр эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн төрийн албан тушаалтныхаа шударга, үнэнч, хариуцлагатай байх явдлыг харгалзан үзэж, дэмжинэ.” гэсний дагуу уг конвенцид нэгдэн орсон улсын хувьд Төрийн албаны тухай хуулийн төрийн жинхэнэ албан тушаалд тавих нийтлэг шаардлагад Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх гэсэн зохицуулалтыг оруулсан бөгөөд хүчин төгөлдөр үйлчилж байна.

Хууль хүн бүрд тэгш үйлчлэх учиртай бөгөөд энэ үүднээс төрийн жинхэнэ албан хаагч нь авлигын гэмт хэрэгт шийтгүүлээд төрд ажиллах эрхгүйтэй адил төрийн улс төрийн албан тушаалтан шийдвэр гаргагч бол авлигын гэмт хэрэгт холбогдоогүй, ял шийтгэлгүй байх ёстой зарчим ижил үйлчлэх ёстой.

Авлига, албан тушаалын гэмт хэрэг нь хэн нэгэн этгээд өөрийн эрх нөлөө, давуу байдлаа ашиглан үйлддэг гэмт хэрэг юм. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд авлига албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглохоор оруулсан зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн

14 дэх заалтад "... Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. ..." гэж заасны дагуу сэжиглэгдэж, шалгагдаж байгаа аливаа этгээдэд хамаарах бус шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр гэм буруутай нь тогтоогдсон этгээдэд хамаарах зохицуулалт юм.

2015 онд шинэчлэн баталсан Эрүүгийн хуульд ялтайд тооцох хугацаа гэсэн зохицуулалтыг хассан учир авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж гэм буруутай нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон хүмүүст нэр дэвших хязгаарлалт байх ёстой. Түүнчлэн нэр дэвшигчид хуульд заасан нийтлэг шаардлагаас гадна банк, бусад хуулийн этгээд, иргэнд шүүх болон арбитрын шийдвэрээр тогтоогдсон төлбөл зохих зээл, барьцаа болон батлан даалтын өр төлбөргүй байх, татварын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх, аль нэг компанийн 51, түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшдэг бол тухайн компани нь албан татварын хугацаа хэтэрсэн өргүй байх болон сонгуульд нэр дэвших төрийн албан хаагчдыг тодорхой хугацааны өмнө ажлаас нь чөлөөлөгдсөн байх шаардлагыг тавьдаг нь иргэн, улс орны нийтлэг эрх ашгийг ямар нэгэн хувийн ашиг сонирхолгүйгээр төлөөлж чадна гэдгийг батлан харуулах нэг нөхцөл юм.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд орсон зохицуулалт нь төрийн дархлааг бэхжүүлэх, иргэд, олон нийтийн эрх ашгийг эрхэмлэн баримтлах хүнийг сонгох бололцоог иргэдэд олгож байгаа чухал зохицуулалт юм. Улс төрд хариуцлагын тогтолцоо сул, төрийн алба хашиж байгаа улс төрчдийн хувьд хувийн ашиг сонирхлын үүднээс албан тушаалаа ашиглан авлига, албан тушаалын гэмт хэрэгт нэр холбогдож байгаагаас иргэдийн төрд итгэх итгэл алдагдаж байна. Энэ нь нөгөө талдаа иргэдийн хуулийг дээдлэн, сахин биелүүлэх ухамсарт сөргөөр нөлөөлж байна.

Дашрамд дурдахад Монгол Улсын хэмжээнд 2017-2019 онд Эрүүгийн хууль /2002 он/-ийн 28 дугаар бүлэг Албан тушаалын гэмт хэрэг, Эрүүгийн хууль /2015 он/-ийн шинэчилсэн найруулгын 22 дугаар бүлэг Авлигын гэмт хэрэгт 606 хүнд холбогдох 204 хэргийг хүлээн авснаас 93 гэмт хэрэгт холбогдсон 200 хүнд ял шийтгэл оногдуулж, эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн байна. Мөн түүнчлэн ял шийтгүүлэгчдийн боловсрол, насны байдал нь сүүлийн 3 жилийн байдлаар нийт ял шийтгүүлсэн хүмүүсээс 138 буюу 81.2 хувь нь дээд, 6 буюу 3.4 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн дунд, 16 буюу 9.4 хувь нь бүрэн дунд, 7 буюу 4.1 хувь нь суурь, 3 буюу 1.8 хувь нь бага боловсролтой хүмүүс, 2016-2018 оны бүтэн жилийн байдлаар насны бүлгээр авч үзвэл 14-15 насны ял шийтгүүлэгчдийн тоо



0.3 хувийг, 16-17 насны ял шийтгүүлэгчдийн тоо 2.2 хувийг, 18-29 насны ял шийтгүүлэгчдийн тоо 64.9 хувийг, 30-34 насны ял шийтгүүлэгчдийн тоо 22.4 хувийг, 35-аас дээш насны ял шийтгүүлэгчдийн тоо 10.3 хувийг тус тус эзэлж байна.” гэсэн байна.

Долоо. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс гаргуулсан “Авлига, албан тушаалын гэмт хэргийг анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн талаарх судалгааны танилцуулга”-д Эрүүгийн хуулийн холбогдох бүлэгт тусгасан гэмт хэрэгт 2015-2019 онд анхан шатны шүүхээр гэм буруутай болох нь тогтоогдож ял шийтгүүлсэн хүний тоо өсөх хандлагатай байна, тодруулбал, 2015 онд 36, 2016 онд 31, 2017 - 53, 2018 - 46, 2019 - 108 байна.

Найм. “Транспэрэнси Интернэшнл-Монгол” байгууллагаас Үндсэн хуулийн цэцэд хандан ирүүлсэн 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 08 дугаар албан бичигт:

“Манай байгууллагын боловсруулан гаргадаг Авлигын төсөөллийн индексийг тэргүүлэгч улсуудын жишгээс харахад гэмт хэрэгт холбогдсон иргэдийн сонгуульд нэр дэвших эрхийг улс өөрийн эрх зүйн орчинд тохируулж зохицуулдаг байна. Энэ нь “Авилгалын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц”-ийн 7 дугаар зүйлийн 2-т “Төрийн албан тушаалд нэр дэвших, сонгох шалгуурыг тогтоох зорилгоор оролцогч улс бүр энэхүү конвенцийн зорилт болон дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн хууль тогтоох болон захиргааны зохих арга хэмжээг авах асуудлыг мөн авч үзнэ” гэж заасны хүрээнд байна. Авлигын төсөөллийн индексийг тэргүүлэгч зарим улсын жишгээс дурдахад:

1. Авлигын төсөөллийн индексийн 1-т орсон Данийн Вант Улсын Үндсэн хуулийн 30 дугаар зүйлд “Ард түмэн Парламентын гишүүн байхад тохиромжгүй гэж үзэх хэргээр яллагдаж байгаагүй бол Парламентын сонгуульд санал өгөх эрхтэй хүн бүр Парламентын гишүүн болох эрхтэй байна.” гэж тусгасан. Мөн парламентын сонгуульд нэр дэвшихэд тохиромжтой эсэхийг Парламентын гишүүд шийдвэрлэдэг. Үндсэн хуулийн хүрээнд ял эдэлсэн гэмт хэрэгтэй хүний Парламентын сонгуульд нэр дэвших эрхийг хязгаарлах боломжтой. Харин татвар төлөхөөс зайлсхийсэн гэмт хэргээр өмнө нь гишүүний статусаа алдаж байсан иргэн ял эдэлж дууссаны дараа дахин сонгуульд нэр дэвшин Парламентын гишүүн болж байсан.

2. Авлигын төсөөллийн индексийн 3-т орсон Бүгд Найрамдах Финланд Улсын Үндсэн хуулийн 27 дугаар зүйлд “сонгуульд санал өгөх

эрхтэй бөгөөд асран хамгаалалтад байдаггүй хүн бүр Парламентын сонгуульд нэр дэвшиж болно” гэж заасан. Тус улс 1995 онд Эрүүгийн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулснаар хувь хүний сонгуульд нэр дэвших эрхийг хасдаггүй болсон байна.

3. Авлигын төсөөллийн индексийн 9-т орсон Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 2-т “18 нас хүрсэн иргэн бүр сонгуульд санал өгөх эрхтэй бөгөөд насанд хүрсэн иргэн бүр сонгогдох эрхтэй”, 3-т “Холбооны хуулиар дэлгэрэнгүй зохицуулалт тогтооно” гэж тус тус заасан. Холбооны сонгуулийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2.1-т “... сонгох эрхээ хасуулсан”, 2.2- т “улс төрийн болон нийтийн алба хашихад тохиромжгүй тухай шүүхийн шийдвэр гарсан бол” сонгуульд нэр дэвшихийг хориглодог байна.

Герман Улсын Эрүүгийн хуулийн 45 зүйлийн 1-т “ноцтой гэмт хэргээр дор хаяж 1 жил хорих ял авсан бол 5 жилийн хугацаанд нийтийн албанд ажиллах эсхүл сонгуульд өрсөлдөх эрхээ хасуулна” гэж заасан. Мөн түүнчлэн Эрүүгийн хуулийн 108e-н 1-т зааснаар Бундестагийн гишүүн хахууль авсан тохиолдолд 5 хүртэлх жил хорих ял, 332 дугаар зүйлд зааснаар нийтийн албан тушаалтан, Европын нийтийн албан тушаалтан эсхүл нийтийн албанд тусгай үүрэг хүлээсэн албан хаагч хахууль авбал 6 сараас 5 жил хүртэлх хугацаанд хорих ял, шүүгч, Европын Холбооны шүүхийн гишүүн эсхүл арбитр хахууль авбал 10 хүртэлх жил тус тус хорих ялтай. Хорих ял дуусгавар болсон өдрөөс эхлэн сонгуульд нэр дэвших эрхийн хязгаарлалт тооцож эхэлдэг байна.” гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад Монгол Улсын иргэн “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно;” хэмээн хуульчилсан билээ. Мөн тус хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно.” хэмээн заажээ.

Үндсэн хуулиар баталгаажсан сонгох, сонгогдох эрх нь улс төрийн эрхийн үндсэн бүрэлдэхүүн бөгөөд сонгох эрхийг Монгол Улсын



эрх зүйн чадамжтай, сонгуулийн эрх бүхий иргэн нийтээрээ эдлэхээр, харин сонгогдох эрхээ хэрэгжүүлэхэд тухайн албан тушаалын онцлогийг харгалзан тусгайлсан болзол, шалгуурыг хуулиар тогтоож болдог. Энэ нь үндсэн хуулийн болон сонгуулийн эрх зүйд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хязгаарлалт бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн зохицуулалтын хүрээнд ч үүнийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэхээр байна.

Сонгогдох эрх нь туйлын эрх биш тул сонгуульд нэр дэвшигчид буюу сонгогдох эрхээ хэрэгжүүлэгч иргэнд шалгуур, болзол, нөхцөл тогтоох нь сонгох эрхийг баталгаажуулахад чиглэгддэг бөгөөд ийнхүү тогтоохдоо Үндсэн хуульт, ардчилсан ёсыг хамгаалах хууль ёсны зорилгод нийцсэн, үндсэн хуулийн эрх зүйн “хэмжээ хэтрэхгүй” байх зарчмын дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн хүрээнд хуулиар тодорхойлох боломжтой байна.

2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2003 оны 58/4 тоот тогтоолоор баталсан Авилгалын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенцид Монгол Улс 2005 оны 10 дугаар сарын 27-ны өдөр нэгдэн орж, Улсын Их Хурлаас соёрхон баталсан байна. Улмаар авлигатай тэмцэх зорилго бүхий Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг баталсан байх бөгөөд хэрэгжилтийг хангах хүрээнд нийтийн албан тушаалтныг сонгох, томилох, огцруулах, халах талаарх эрх зүйн орчинг тодорхой болгож, холбогдох шаардлагыг тухайн харилцааг нарийвчлан зохицуулсан хуулиудад тусгах зэргээр шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд “нийтийн албан тушаалтан”-д төрийн улс төрийн албан тушаалтан, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигчийг хамааруулан хуульчилжээ. Мөн нийтийн албан тушаалтан нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хувийн ашиг сонирхлоосоо ангид тэгш, шударга, хариуцлагатайгаар хэрэгжүүлж, олон нийтийн итгэл даах байдлыг ханган ажиллахыг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд тусгажээ.

Үүнээс үзэхэд, Монгол Улсын Үндсэн хуулийн заалт болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, түүгээр хүлээсэн үүрэг, холбогдох

хуулийн зохицуулалт, авлигаас ангид байж хууль дээдлэх ёсыг хангах бодлогын хүрээнд Монгол Улсын Их Хурал 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8 дахь хэсэгт авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглохоор аливаа ялгаварлалгүйгээр хуульчилсан гэж үзэхээр байна.

3. Дэлхийн 123 улсын эрх зүйн зохицуулалтад сонгуулийн эрхийг хэрэгжүүлэхэд тавигдах шалгуурыг хэрхэн тусгасан талаарх (2015 оны) судалгаанаас харахад шалгуур тогтоосон байдлаар нь ерөнхийд нь чөлөөт, энгийн, сонгодог гэсэн 3 загварт хувааж үзсэн байна. Уг судалгаагаар Монгол Улс нь 54 орны хамт сонгодог загварт багтсан байх ба тус загварт болон энгийн загварт хамаарах нийт 113 оронд гэмт хэрэгт холбогдсон эсэхийг шалгуур болгон сонгуулийн эрхэнд хязгаарлалт тогтоосон хуулийн зохицуулалт үйлчилж байна.

Мөн Европын Холбооны Венецийн комиссоос Европын орнууд болон бусад хэд хэдэн орны хууль тогтоомжийн хүрээнд 2015 онд хийсэн гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон этгээдийн парламентад нэр дэвших эрхийг хязгаарлах талаарх судалгааны тайлан болон гадаадын зарим улсын сонгуулийн тухай хуулиас үзэхэд нийтийн албан тушаалтан гэмт хэрэг, ялангуяа авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж эрүүгийн хариуцлага хүлээсэн бол хууль тогтоох байгууллагын сонгуульд нэр дэвших эрхийг хуулиар хасах, хязгаарлах зохицуулалт нийтлэг хэрэглэгдэж байна. Дээр дурдсан тайланд нийтийн ашиг сонирхлын эсрэг, эсхүл ноцтой гэмт хэрэг үйлдсэн хүнээр улс төрийн (тухайн улсын нийт иргэн, улсын ашиг сонирхлын хүрээнд) шийдвэр гаргуулахгүй байх нь олон нийтийн ашиг сонирхолд нийцэх бөгөөд энэ нь иргэдийн хууль ёсны итгэлийг хамгаалах нийтийн эрх зүйн зарчимд үндэслэгдэнэ гэжээ.

4. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 21, 29 дүгээр зүйл болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 25 дугаар зүйлийн зохицуулалтаас үзэхэд сонгууль явуулах суурь зарчмуудыг тодорхойлон баталгаажуулсан байна. Харин уг зохицуулалтуудын талаарх Нэгдсэн Үндэстний Байгууллагын бүтцийн байгууллага болон хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагаас гаргасан ерөнхий тодотгол, тайлбар зэрэгт сонгуулийн зарчмын ойлголт, агуулгыг нийтлэг байдлаар тунхагласан бөгөөд тэдгээрийн агуулгыг нээн дэлгэрүүлэх, баяжуулах боломжийг улс орон бүрийн бүрэн эрхэд үлдээсэн байдаг.



5. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хурлаас 2005 онд баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлээд 06 дугаар дүгнэлт гаргасан байна. Уг дүгнэлтийн “Үндэслэл” хэсэгт “1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд буй “Ялгүй байх” гэсэн ойлголт нь ... өмнө нь огт ял шийтгүүлж байгаагүй гэсэн агуулгыг илэрхийлж байна. 2. Хууль тогтоогч Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэр дэвшигчид тавих шаардлагад “Ялгүй байх” гэсэн заалтыг оруулснаараа ялгүйд тооцох гэсэн ойлголтоос агуулгын хувьд өөрчлөгдөж Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээдийн улс төрийн эрх буюу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох эрхийг ял шийтгүүлсний дараа бүх насаар нь хязгаарлаж байгаагаараа Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулсан байна.” гэжээ. Тодруулбал, дээрх хуулийн заалтаар нэр дэвшигчид огт ял шийтгүүлж байгаагүй гэх шалгуур тавьж, аливаа гэмт хэргийг буюу санаатай, эсхүл болгоомжгүй, түүнчлэн санаатай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас болгоомжгүйгээр хохирол, хор уршигт хүргэсэн гэм буруугүйн холимог хэлбэрийг өргөн хүрээнд хамааруулж тус ойлголтыг хуульчилсан нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн хэмээн дүгнэлт гаргах үндэслэл болсон гэж үзэхээр байна.

Харин Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8 дахь хэсгийн “Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно.” гэсэн заалт нь тодорхой төрлийн гэмт хэргийг нэрлэн зааж хязгаарлалт тогтоон хуульчилсан зохицуулалт байх бөгөөд Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн дунд суудлын хуралдаанаар хэлэлцсэн 2005 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтаас агуулга, зарчмын хувьд өөр байна.

6. Монгол Улсад шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш явагдсан Монгол Улсын Их Хурлын 7 удаагийн сонгууль нь 1992, 2005, 2011, 2015 онд батлагдсан хуулиудын дагуу зохион байгуулагдсан бөгөөд Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8 дахь хэсгийн зохицуулалт нь өнөөгийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, төрийн бодлогын хүрээнд хуульчлагдсан хязгаарлалт гэж үзэхээр байх тул иргэний сонгогдох эрхийг бүх насаар нь хязгаарласан хэмээн шууд дүгнэх үндэслэлгүй байна.

7. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8 дахь хэсэгт “Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно.” гэж хуульчилж авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон эсэхийг Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчид тавих шалгуур болгож, Монгол Улсын төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох онцгой бүрэн эрхийг хэрэгжүүлдэг төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хуралд сонгогдож нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримталж Үндсэн хууль болон холбогдох хуулийн хүрээнд чиг үүргээ хэрэгжүүлдэг Улсын Их Хурлын гишүүний албан тушаалын онцлогийг харгалзан ардчилсан нийгмийн ёс суртахууны шударга шаардлагыг хангахад чиглэгдсэн тусгай шалгуурыг нэр дэвшигчид хуулиар тогтоосон нь хууль тогтоогчийн онцгой бүрэн эрхэд хамаарч байна.

8. Монгол Улсын Их Хурлын сонгуульд авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон хүнийг нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзахаар тусгаж, Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тодорхой гэмт хэрэг үйлдэж гэм буруутай болох нь шүүхээр тогтоогдсон иргэний сонгогдох эрхийг хязгаарлах нь давхардуулан ял оногдуулж байгаа эрүүгийн хариуцлага бус харин бусад салбар эрх зүйн хариуцлагын үндсэн дээр үүсдэг үндсэн хуулийн эрх зүйн хариуцлагын нэг төрөл, нийтийн засгийг авлигаас /гэмт хэргээс/ ангид байлгах урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээ, иргэний сонгох эрхийг баталгаажуулах арга гэдгийг тэмдэглэх нь зүйтэй юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1, Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8 дахь хэсэгт “Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... шударга ёс, ... тэгш байдал ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад засгийн



бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал, ... үзэл бодол ...-оор нь ялгаварлан гадуурхаж үл болно.”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...”, мөн зүйлийн 10 дахь заалтын “... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Хорин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно.” гэж заасныг тус тус зөрчөөгүй байна.

2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.9 дэх заалтад “авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаарх холбогдох байгууллагын лавлагаа.”, мөн зүйлийн 32.3.11 дэх заалтад “авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаарх холбогдох байгууллагын лавлагаа.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...”, Хорин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно.” гэж заасныг тус тус зөрчөөгүй байна.

3.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГАЛАГЧ
ГИШҮҮД**

**Б.БУЯНДЭЛГЭР
Д.СОЛОНГО
Г.ТУУЛХҮҮ
Ц.НАНЗАДДОРЖ
Г.БАЯСГАЛАН**

МОНГОЛ УЛС ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

МОНГОЛ УЛС

Болон

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК (АХБ)

хоорондын

**САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ХӨТӨЛБӨРТ
ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ**

2019-2020 ОНЫ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Монгол Улсын Улаанбаатар хотноо Монгол Улс, АХБ 2019 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр (“Ерөнхий хөтөлбөр”)-ийг байгуулсан. Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр нь Монгол Улсын Их Хурлаар 2019 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр соёрхон батлагдаж, хууль болсон.
2. Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг Монгол Улстай хамтран хэрэгжүүлэх хамтын ажиллагааны стратеги (2017-2020), Үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө (2019-2021) болон Үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө (2020-2021)-ний дагуу үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын хүсэлтээр болон АХБ-тай зөвшилцсөний үндсэн дээр Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулахаар тохиров.

(а) Удиртгал (А)-г дараах байдлаар өөрчлөв. Үүнд:

“(А) Монгол Улс Монгол Улстай хамтран хэрэгжүүлэх хамтын ажиллагааны стратеги (2017-2020), Үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө (2019-2021), болон Үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө (2020-2021)-ний дагуу 2019-2020 онд хөгжлийн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор АХБ-аас зээлийн санхүүжилт хүсч болно.”

(б) Нэгдүгээр зүйлийн Хэсэг 1.01 (б)-г дараах байдлаар өөрчлөв. Үүнд:

“(б) 2020 онд зуун далан сая ам.доллар (170,000,000 ам.доллар)¹-ыг АХБ-ны энгийн эх үүсвэрийн сангийн энгийн болон хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлж болно.”

¹ АХБ-аас 2020 онд Монгол Улсад зуун сая ам.доллар (100,000,000 ам.доллар)-ыг Монгол Улсаас тавьсан хүсэлтийн дагуу эрчим хүчний чиглэлийн хөгжлийн төслийг санхүүжүүлэх зорилгоор нэмэлтээр олгохоор болсон.



(в) Нэгдүгээр зүйлийн Хэсэг 1.02-г дараах байдлаар өөрчлөв. Үүнд:

“Хөгжлийн төсөл эсхүл хөтөлбөр тус бүрийн санхүүжилтийн хэмжээг Монгол Улс, АХБ хооронд байгуулах зээлийн хэлэлцээрийн хүрээнд тохирно. Хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийн ерөнхий мэдээлэл Үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө (2019-2021) болон Үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө (2020-2021)-нд туссан болно. Монгол Улс өөрийн нутаг дэвсгэр дээр гарах нэмэгдсэн өртгийн албан татвар болон гаалийн татвараас чөлөөлөх хэлбэрээр санхүүжилт гаргаж болно.”

3. Дээр дурдсан заалтуудаас бусад тохиолдолд Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр хэвээр үлдэнэ.
4. Энэхүү Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрт оруулах нэмэлт өөрчлөлт нь Монгол Улсын Их Хурал соёрхон баталсан өдрөөр хүчин төгөлдөр болж, Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр хүчин төгөлдөр байх хугацаанд мөн хүчин төгөлдөр байна.
5. Энэхүү Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрт оруулах нэмэлт өөрчлөлт нь Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн салшгүй хэсэг байх ба Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөртэй ижил хууль зүйн хүчин чадалтай байна.

—Заалтуудын төгсгөл—

Монгол Улс, АХБ хооронд тохиролцсон дээрх заалтуудыг энд хөрвүүлсэн болно.

Хөтөлбөрт оруулах нэмэлт, өөрчлөлтийг 2020 оны 2 дугаар сарын 07-ны өдөр Англи хэл дээр 2 хувь байгуулсан ба эх бичвэр бүр ижил хүчинтэй байна.

МОНГОЛ УЛСЫГ төлөөлж

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКЫГ төлөөлж

.....
САНГИЙН САЙД
Ч.ХҮРЭЛБААТАР

.....
МОНГОЛ УЛСЫГ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ
ПАВИТ РАМАЧАНДРАН

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 3,5

Индекс: 200003